

СЭТГЭЛ СУДЛАЛ-БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛ СУДЛАЛ

ЭЦЭГ ЭХИЙН ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ЗӨРЧИЛ БА ХҮҮХДИЙН ХАРИЛЦААНЫ ХЭВ ШИНЖИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА

Л. Уранзаяа
Магистрант

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан, технологийн их сургууль

☎ 0009-0000-1154-8547

DOI: 10.66753/

zayaka.zayets@gmail.com

Н. Ариунтуяа
Доктор (Ph. D.), дэд профессор

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан, технологийн их сургууль

☎ 0000-0003-0878-050X

DOI: 10.66753/

ariuntuya.n@must.edu.mn

Хураангуй: Энэхүү судалгаа нь эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил болон фрустрацид хандах хариу үйлдэл нь хүүхдийн харилцааны хэв шинжид хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зорилготой. Судалгаанд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 3-р ангийн сурагчид, тэдний эцэг эхчүүдийг хамруулж асуумж болон Розенцвейгийн зурган тестийн аргаар мэдээлэл цуглуулсан. Судалгааны үр дүнг SPSS программ ашиглан статистик боловсруулалт хийж, корреляц болон регрессийн шинжилгээ хийв. Үр дүнгээс харахад эцэг эхийн харилцааны зөрчил болон хариу үйлдлийн хэв шинж нь хүүхдийн харилцааны хэв шинжид статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж байгааг тогтоолоо.

Түлхүүр үг: Фрустрацийн хариу үйлдэл, хүүхдийн зан үйл, хариу үйлдлийн хэв шинж, гэр бүлийн уур амьсгал, нийгэм-сэтгэл зүйн нөлөөлөл

УДИРТГАЛ

Гэр бүл нь хүүхдийн нийгэмшил, сэтгэл зүйн төлөвшлийн хамгийн анхдагч бөгөөд чухал орчин юм. Хүүхэд харилцааны хэв маяг, зан үйл, сэтгэл хөдлөлийн илэрхийллээ анхлан гэр бүлийн орчноос сурч, эцэг эхийн харилцааг загвар болгон төлөвшдөг. Иймээс эцэг эхийн хоорондын харилцаа, тэр дундаа

зөрчилдөөн нь хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв, бусадтай харилцах харилцаанд шууд болон шууд бус нөлөө үзүүлдэг.

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн дарамт, архидалт, ажилгүйдэл, ядуурал зэрэг хүчин зүйлсийн улмаас гэр бүлийн харилцааны зөрчил нэмэгдэж, үүний хамгийн эмзэг хохирогч нь хүүхдүүд болж байна. Эцэг эхийн маргаан, үл ойлголцол нь хүүхдэд айдас, түгшүүр, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах, үе тэнгийнхэнтэйгээ харилцахад бэрхшээл үүсэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог. Улмаар эдгээр сэтгэл зүйн өөрчлөлтүүд нь хүүхдийн зан төлөв, харилцааны хэв шинжид тогтвортой нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

2020–2025 оны хооронд Монгол Улсад жил бүр 10 мянгаас дээш тооны гэр бүлийн хүчирхийллийн зөрчил бүртгэгдэж байгаа нь гэр бүлийн харилцааны асуудал тогтвортой өндөр түвшинд байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч Монголын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хүүхдүүдийн харилцааны хэв шинжид эцэг эхийн хоорондын зөрчил хэрхэн нөлөөлж байгааг системтэйгээр судалсан судалгаа хомс хэвээр байна. Иймээс энэхүү судалгаагаар эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил болон зөрчилдөөнд хандах хариу үйлдлийн хэв шинж нь хүүхдийн харилцааны хэв шинжид ямар хэлбэрээр, хэрхэн нөлөөлж байгааг тодруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү судалгааны зорилго нь эцэг эхийн харилцааны зөрчил болон харилцааны хэв шинж нь хүүхдийн харилцааны хэв шинжид хэрхэн нөлөөлж буйг судлахад оршино. Судалгаанд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагчид болон тэдний эцэг эхийг хамруулж, асуумж болон Розенцвейгийн зурган тестийн аргаар мэдээлэл цуглуулан, SPSS программ ашиглан статистик боловсруулалт хийв.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил нь гэр бүлийн тогтолцооны дотоод уур амьсгалд нөлөөлөхөөс гадна хүүхдийн сэтгэл зүйн хөгжил, зан төлөв, харилцааны хэв шинжид чухал нөлөө үзүүлдэг сэтгэл зүйн хүчин зүйл юм. Судлаачид зөрчлийг хэрэгцээ, сонирхол, үнэт зүйлийн зөрчилдөөнөөс үүсдэг нийгэм-сэтгэл зүйн үзэгдэл хэмээн тодорхойлдог бөгөөд зөрчил нь нэг талаас сөрөг үр дагавартай боловч нөгөө талаас харилцааг шинэчлэх, асуудлыг ил тод болгох эерэг үүрэгтэй байж болохыг онцолдог [Нандинцэцэг, 2012].

Гэр бүлийн орчин нь хүүхдийн нийгэмшил, зан төлөв, харилцааны анхны загвар бүрэлддэг суурь орчин юм. Л.С.Выготскийн Нийгэм-соёлын хөгжлийн онолоор хүүхдийн танин мэдэхүйн хөгжил нь нийгэм, соёл, бусадтай харилцах харилцаагаар дамжин хөгжих бөгөөд ойр дотны насанд

хүрэгчдийн, ялангуяа эцэг эхийн харилцааны хэв маяг хүүхдийн сэтгэл зүйн хөгжилд шууд нөлөөлдөг гэж үздэг. Иймээс эцэг эхийн хоорондын харилцаа нь хүүхдийн харилцааны хэв шинжийн загвар болж төлөвшдөг [Выготский, 1978].

Нийгмээс суралцахуйн онолын хүрээнд Альберт Бандура хүүхэд зан үйл, харилцааны хэв маягийг шууд зааварчилгаанаас илүүтэйгээр ажиглалт, даган дуурайх байдлаар сурдаг болохыг онцолсон. Хүүхэд эцэг эхийн хоорондын маргаан, харилцааны хэлбэрийг ажиглаж, түүнийг асуудал шийдвэрлэх арга, харилцах хэв маягийн жишээ болгон эзэмшдэг. Иймд зөрчилдөөнтэй орчинд өссөн хүүхэд бухимдлаа бусдад чиглүүлэх, өөрийгөө хамгаалах, эсвэл асуудлаас зайлсхийх хандлага төлөвших эрсдэлтэй байдаг [Bandura, 1977].

Фрустрацийн онолын үүднээс авч үзвэл, хэрэгцээ хангагдахгүй байх, саад бэрхшээл тулгарах үед үүсэх сэтгэл зүйн дарамт нь хувь хүний хариу үйлдлийн хэв шинжээр илэрдэг. Розенцвэйг фрустрацид үзүүлэх хариу үйлдлийг саад бэрхшээлд төвлөрсөн (OD), өөрийгөө хамгаалсан (ED), шийдэлд төвлөрсөн (NP) гэсэн үндсэн чиглэлээр ангилсан. Эдгээр хариу үйлдлийн хэв шинж нь хүний асуудалд хандах хандлага, харилцааны арга барилтай шууд холбоотой бөгөөд гэр бүлийн харилцаанд үүсэх зөрчил нь эдгээр хэв шинжийг өдөөх хүчин зүйл болдог. Мөн хариултыг бухимдлын чиглэлээс хамааруулан 3 ангилсан. **Экстрапунитив чиглэл:** Энэ хэв шинжийн хүмүүсийн хариу үйлдэл амьд, амьд биш зүйл рүү чиглэнэ. Фрустраци буюу уур бухимдал, сөрөг мэдрэмжийг гадагш чиглүүлж бусдад бурууг тохох хандлагатай. Мөн заримдаа бусдаас нөхцөл байдлыг шийдвэрлэхийг хүсдэг. **Интропунитив чиглэл:** Өөрт чиглэсэн, өөрийгөө буруутгасан эсвэл үүссэн нөхцөл байдлыг засаж өөрчлөх хандлагатай. Нөхцөл, шалтгааныг хэлэлцэхээс зайлсхийх байдалтай. **Инпунитив чиглэл:** Фрустраци үүсгэх нөхцөлийг үл ялих, зайлшгүй байх зүйл гэж үзэхээс гадна цаг хугацааны явцад шийдэгдэнэ гэж үзээд өөрийгөө ба бусдыг үл буруутгах байдал илэрдэг. [Rosenzweig, 1945].

Хүүхдийн сэтгэцийн хөгжил, насны үечлэлийн онолоор сургуулийн бага насанд (ойролцоогоор 7–11 нас) хүүхэд нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, үе тэнгийнхэнтэйгээ харилцах чадвар эрчимтэй хөгждөг. Энэ үед гэр бүлийн уур амьсгал, эцэг эхийн хоорондын харилцаа нь хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэл хөдлөлийн тогтвортой байдал, харилцааны хэв шинжид онцгой нөлөө үзүүлдэг [Эльконин, 1989; Санжжав, 2013]

Иймээс энэхүү судалгаанд эцэг эхийн харилцааны зөрчил болон зөрчилдөөнд хандах хариу үйлдлийн хэв шинжийг Розенцвэйгийн зурган тестээр тодорхойлж, тэдгээр нь хүүхдийн харилцааны хэв шинжтэй хэрхэн

уялдаж байгааг харьцуулан шинжлэх онол, арга зүйн үндэслэл болгож ашиглав.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашиглав. Судалгааны түүврийг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагчид болон тэдний эцэг эхээс бүрдүүлсэн. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн насны онцлог, сэтгэцийн хөгжлийн түвшин, эцэг эхийн гэр бүлийн харилцааны онцлогийг харгалзан сонгож, нийт 50 эцэг эх, 50 хүүхдийг хамруулсан.

Мэдээлэл цуглуулахдаа эцэг эхчүүдэд зориулсан асуумжийг ашиглан гэр бүлийн харилцааны зөрчлийн давтамж, хэлбэр, илрэх нөхцөл байдлыг тодорхойлов. Мөн насанд хүрэгчдэд зориулсан Розенцвэйгийн зурган тестийг ашиглан эцэг эхийн зөрчилдөөнд хандах сэтгэл зүйн хариу үйлдлийн хэв шинжийг тодорхойлсон. Хүүхдэд зориулсан Розенцвэйгийн зурган тестийг ашиглан хүүхдийн бухимдал, саад бэрхшээлтэй нөхцөлд үзүүлэх хариу үйлдэл, харилцааны чиг хандлагыг илрүүлэв.

Цуглуулсан мэдээллийг SPSS программ ашиглан статистик боловсруулалт хийж, корреляцийн шинжилгээгээр хувьсагчдын хоорондын хамаарлыг, регрессийн шинжилгээгээр эцэг эхийн хариу үйлдлийн хэв шинж нь хүүхдийн харилцааны хэв шинжид үзүүлэх нөлөөллийг үнэлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад эцэг эхийн “саад бэрхшээлд төвлөрсөн”, “бусдыг буруутгасан”, “шийдэлд төвлөрсөн” хариу үйлдлийн хэв шинжүүд болон уур бухимдлын “бусдыг буруутгасан”, “өөрийгөө буруутгасан”, “хариуцлагыг багасгасан” чиглэлүүд нь хүүхдийн харилцааны чиг хандлагатай статистикийн ач холбогдолтой хамааралтай байгааг тогтоосон.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгааны үр дүн нь эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил болон зөрчилдөөнд хандах хариу үйлдлийн хэв шинж нь хүүхдийн харилцааны хэв шинжид статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж байгааг нотолж байна. Тодруулбал, эцэг эхийн саад бэрхшээлд төвлөрсөн (P-OD) болон бусдыг буруутгасан (P-E) хариу үйлдлийн хэв шинж өндөр байх тусам хүүхдийн мөн адил саад бэрхшээлд төвлөрсөн (CH-OD) болон бусдыг буруутгасан (CH-E) чиглэлийн хандлага нэмэгдэх хандлагатай гарсан нь эцэг эхийн харилцааны загвар хүүхдийн харилцааны хэв шинжид шууд нөлөөлж байгааг харуулж байна. Энэ үр дүн нь хүүхэд эцэг эхийн зөрчилдөөнд хандах сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, зан үйлийн хэв маягийг ажиглан дуурайж,

түүнийг эзэмшиж байгааг илтгэх бөгөөд Нийгмээс суралцахуйн онолын суурь ойлголттой бүрэн нийцэж байна.

Альберт Бандурагийн Нийгмээс суралцахуйн онолоор хүүхэд зан үйл, харилцааны хэв маягийг шууд зааварчилгаанаас илүүтэйгээр ажиглалт, даган дуурайлтаар суралцдаг гэж үздэг. Иймээс эцэг эхийн хоорондын маргаан, бухимдлыг илэрхийлэх хэлбэр, асуудалд хандах хандлага нь хүүхдийн хувьд асуудал шийдвэрлэх “зөвшөөрөгдсөн” загвар болон төлөвших бөгөөд цаашид түүний харилцааны хэв шинжийн суурь болж тогтдог байна. Энэ нь гэр бүлийн орчинд илэрч буй сөрөг харилцааны хэв маяг хүүхдийн нийгэмших үйл явцад сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг харуулж байна. Мөн хүүхдийн асуудалд төвлөрсөн хариу үйлдлийн хэв шинж (CH-OD) болон шийдэлд төвлөрсөн хариу үйлдлийн хэв шинж (CH-NP) хоорондоо сөрөг хамааралтай, ач холбогдолтой гарсан нь хүүхэд бэрхшээлд төвлөрөх тусам асуудал шийдвэрлэх, асуудалд тайван хандах чадвар нь буурч байгаагаас харж болно.

Мөн эцэг эхийн шийдэлд төвлөрсөн (P-NP) хариу үйлдлийн хэв шинж нь хүүхдийн шийдэлд төвлөрсөн (CH-NP) болон зохицсон, эерэг харилцааны хэв шинжтэй статистикийн ач холбогдолтой эерэг хамааралтай гарсан нь анхаарал татаж байна. Энэ нь эцэг эх асуудлыг тайван, хариуцлагатай, бүтээлч байдлаар шийдвэрлэдэг байх үед хүүхэд мөн адил асуудалд эерэг, шийдэл эрэлхийлсэн, харилцан ойлголцолд чиглэсэн хандлага төлөвшиж байгааг илтгэнэ. Ийм үр дүн нь Hess (2021), Jouriles нарын (2008) судалгааны дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд эцэг эхийн харилцааны уур амьсгал нь хүүхдийн нийгмийн дасан зохицол, үе тэнгийнхэнтэй харилцах харилцаанд хамгаалах хүчин зүйл болж чадахыг нотолж байна.

Эцэг эхийн өөрийгөө буруутгасан (P-I) болон асуудлыг зөөлрүүлсэн, хүлээлтийн (P-M) хэв шинжүүд нь хүүхдийн дотогш чиглэсэн (CH-I) хариу үйлдэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурахтай хамааралтай гарсан нь хүүхэд гэр бүлийн орчны сэтгэл зүйн уур амьсгалыг мэдэрч, өөрийгөө буруутгах, дотогш чиглэсэн хамгаалах механизм төлөвшүүлэх эрсдэлтэй болохыг харуулж байна. Энэ үр дүнг Л.С.Выготскийн Нийгэм-соёлын хөгжлийн онолоор тайлбарлаж болох бөгөөд ойр дотны насанд хүрэгчдийн сэтгэл зүйн байдал, харилцааны хэв маяг нь хүүхдийн дотоод сэтгэл зүйн бүтэц, өөрийгөө ойлгох ойлголтод шууд нөлөөлдөг болохыг илтгэнэ.

Иймээс энэхүү судалгааны үр дүн нь эцэг эхийн харилцааны зөрчил нь зөвхөн эхнэр, нөхрийн хоорондын харилцааны асуудал бус, харин хүүхдийн зан төлөв, харилцааны хэв шинжид урт хугацааны, тогтвортой нөлөө үзүүлдэг сэтгэл зүйн чухал хүчин зүйл болохыг нотолж байна. Эцэг эхийн харилцааны зөрчлийг зөв зохицуулах, харилцааны эерэг хэв маягийг төлөвшүүлэх,

асуудлыг шийдэлд чиглүүлэн авч үзэх чадварыг дэмжих нь хүүхдийн сэтгэл зүйн эрүүл хөгжил, нийгэмших үйл явцыг хамгаалах, дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

ДҮГНЭЛТ

1. Эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил нь ихэнх гэр бүлд байнгын, хурц хэлбэрээр бус харин тодорхой нөхцөл байдал, сэтгэл зүйн ачаалал, стрессийн нөлөөгөөр үе үе илэрдэг түгээмэл нийгэм-сэтгэл зүйн үзэгдэл болох нь тогтоогдлоо. Энэ нь гэр бүлийн харилцаа гадна талаасаа тогтвортой мэт харагдавч дотоодод тодорхой хэмжээний зөрчил, үл зохицол хадгалагдаж байдгийг илтгэж байна.

2. Гэр бүлийн зөрчил үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн дотроос хосуудын хувь хүний онцлог (зан төлөв, сэтгэл зүйн хэв шинж, харилцааны арга барил, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх болон удирдах чадвар) хамгийн өндөр нөлөөтэй байгаа нь харилцааг зохицуулах ур чадвар дутмаг байх нь зөрчлийг бий болгох үндсэн шалтгаан болж байгааг харуулж байна.

3. Статистик шинжилгээгээр эцэг эхийн харилцааны хэв шинж болон хүүхдийн харилцааны хэв шинжийн хооронд утга бүхий, тогтвортой хамаарал илэрсэн нь хүүхэд эцэг эхийнхээ харилцааны зан үйлийг ажиглан суралцаж, улмаар түүнийг өөрийн зан төлөв, харилцааны хэв маяг болгон төлөвшүүлдэг зүй тогтлыг нотолж байна.

4. Харилцааны зөрчил давтамжтай илэрдэг, зохицуулалт сул гэр бүлийн орчинд өсч буй хүүхдүүдэд бусдыг буруутгах, өөрийгөө хамгаалах, бухимдлаа дотроо хадгалах эсвэл нөхцөл байдалд хэт дасан зохицох зэрэг сөрөг харилцааны хэв шинж илүүтэй илэрч байгааг судалгааны үр дүн харууллаа.

5. Эцэг эхийн хоорондын харилцааны зөрчил нь зөвхөн хосуудын хүрээнд хязгаарлагдах асуудал бус, гэр бүлийн уур амьсгал, хүүхдийн сэтгэл зүй, цаашдын харилцааны хэв шинжид урт хугацааны нөлөө үзүүлэх олон талт нийгэм-сэтгэл зүйн чухал хүчин зүйл болох нь уг судалгаагаар нотлогдлоо. Иймд гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх аргуудад суралцах, эцэг эхийн харилцааны чадварыг сайжруулах нь хүүхдийн сэтгэл зүйн эрүүл хөгжилд чухал ач холбогдолтой болохыг анхаарах шаардлагатай байна.

НОМЗҮЙ

1. Баньдхүү, Г. (2016). *Гэр бүлийн сэтгэл судлал. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].*

2. Батаабаатар. (2015). *Гэр бүлийн харилцааны зарим асуудал [Блог бичвэр].*

3. https://bataabaatar.blogspot.com/2015/03/blogpost_19.html

4. Довдон, Ц. (2012). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].*

5. Доржжав. (2008). *Харилцааны сэтгэл зүйн ертөнц. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].*

6. Сарантуяа, Г. (2023). Сэтгэц оношилгоо. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
7. Ичинхорлоо, Ш. (2013). Хүүхдийн хөгжил. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
8. Мандах, З. (2006). Гэр бүлийн сэтгэл зүй. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
9. Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2013). Бага насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар: МУБИС.
10. Мягмар, О. (2002). Харилцааны сэтгэл зүй. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
11. Мягмар, О. (2019). Сэтгэц заслын зөвлөгөөний онол, арга зүй. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
12. Намжил, Т. (2006). Гэр бүл: Харилцаа. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
13. Нандинцэцэг, Б. (2012). Гэр бүлийн харилцааны зарим асуудал. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
14. Санжсжав, Д. (2013). Хүүхдийн нас зүй, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
15. Уугантуяа, М. (2013). Бага насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
16. Хишиг-Ундрах, М. (2018). Хүүхдийн сэтгэл зүйн ертөнц. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
17. Энхбаяр, Б. (2017). Харилцааны сэтгэл зүй. Улаанбаатар: [Хэвлэлийн газар тодорхойгүй].
18. Baumrind, D. (1991). The influence of parenting style on adolescent competence and substance use. *Journal of Early Adolescence*, 11(1), 56–95. <https://doi.org/10.1177/0272431691111004>
19. Bowlby, J. (1988). *A secure base: Parent–child attachment and healthy human development*. New York, NY: Basic Books.
20. Bronfenbrenner, U. (1979). *The ecology of human development: Experiments by nature and design*. [1] Cambridge, MA: Harvard University Press.
- EBSCO. (n.d.). *Social learning theory*.
21. <https://www.ebsco.com/research-starters/education/social-learning-theory>
22. Pettijohn, T. F. (1992). *Psychology: A concise introduction*. New York, NY: HarperCollins.
23. UNICEF. (2022). *Psychosocial risks for children during school closure*.
24. <https://www.unicef.org/mongolia/media/4516/file/PSYCHOSOCIAL%20RISKS%20FOR%20CHILDREN%20DURING%20SCHOOL%20CLOSURE.pdf>